

МОНГОЛ, ХЯТАДЫН ШИНЭ ЖАРНЫ ХАРИЛЦАА ШИНЭ ШАТАНД ГАРЛАА

*Л.Бэгзжав**

(БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаогийн Монгол Улсад хийсэн айлчлалын тухайд)

1949 оны 10-р сарын 16-нд, Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш нэгэн жарны түүх улирч (1949-2009), шинэ жарны харилцааны түүхийн шинэхэн хуудас баялаг үйл явдлаар дүүрэн эхэлж байна. Монгол Улсын дөрөв дэх ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн БНХАУ-д 2010 оны 4-р сарын 28-наас 5-р сарын 4-нд хийсэн төрийн айлчлал Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг шинэ агуулгаар баяжуулан, шинэ шатанд ахиулан хөгжүүлэхэд шинэ түлхэц өгсөн айлчлал байлаа.

Хятад бол Монголын хамгийн том худалдааны түнш, хамгийн том хөрөнгө оруулалтын эх үүсвэр улс юм. 1998-2008 онд хоёр улсын худалдааны эргэлт 243 сая ам.доллараас 2,438 тэрбум ам.долларт хүрч бараг 10 дахин нэмэгдлээ. Тоо бүртгэлийн мэдээгээр, 2009 онд Монгол, Хятадын худалдааны хэмжээ 2,397 тэрбум ам.доллар, түүний дотор Хятадын талын экспорт 1,058 тэрбум ам.доллар, импорт 1,339 тэрбум ам.долларт хүрчээ. Хятад улс 11 жил дараалан Монголын худалдааны хамгийн том түншийн байр сууриа хадгалсаар байна. 2009 онд Хятад улсаас Монголд 116 сая ам.долларын хөрөнгө оруулж, бодит хөрөнгө оруулалтын хэмжээ 101,1 сая ам.доллар болж, Хятад Улс 12 жил дараалан Монголд хамгийн их хөрөнгө оруулагч улс болоод байна.¹ Өнөөдрийн байдлаар Монгол Улсад БНХАУ-ын 2,3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай 4927 аж ахуйн нэгж байгаа албан ёсны бүртгэлийн мэдээ байна.

Хятад улс эргэн тойрны улс орнууддаа “хөршдөө тусалж, хөрштэйгээ түншлэх” гадаад бодлого баримталж, энэ зарчмыг удирдлага болгосноор Хятад, Монгол хоёр улс нягт дотно хөрш, өнө үүрдийн түнш орон байх болно гэж Бээжингийн олон улс судлалын эрдэмтэн Гун Вэньжи өгүүлсэн байна.²

Хоёр орны удирдагчдын дээд түвшиний уулзалтын давтамж, харилцан айлчлал улам бүр амжилттай болж, ахин дэвшсээр байгаагийн бодит биелэл нь БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаогийн 2010 оны 6-р сарын 1-2-ны өдөр Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал юм.

Түүх сөхвөөс, хоёр орны Засгийн газрын тэргүүн нар өнгөрсөн жаранд хэдэнтээ харилцан айлчилжээ.

* Л.Бэгзжав - ОСУХ-ийн Хятад судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор

1952 оны 9-р сарын 28-наас 10-р сарын 17-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй Монголын Засгийн газрын төлөөлөгчид БНХАУ-д анх удаа албан ёсны айлчлал хийж, шинэ Хятад улс байгуулагдсаны 3 жилийн ойн ёслолын арга хэмжээнд оролцов.

Хоёр тал 1952 оны 10-р сарын 4-нд БНМАУ ба БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт Бээжин хотноо гарын үсэг зуржээ. Энэхүү хэлэлцээр нь хоёр орны харилцаа хамтын ажиллагааны үндэс суурийг тавьсан түүхэн ач холбогдолтой баримт бичиг байлаа.

БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Энълай,³ Ерөнхий сайдын орлогч бөгөөд ГЯЯ-ны сайд Чэнь И тэргүүтэй Хятадын Засгийн газрын дээд хэмжээний төлөөлөгчид 1960 оны 5-р сарын 27-ноос 6-р сарын 1-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Хоёр орны Засгийн газрын тэргүүн нар 1960 оны 5-р сарын 31-нд “Монгол, Хятадын найрамдал, харилцан туслалцах гэрээ” байгуулсан нь Монгол Улсын тухайд, хил залгаа хоёр том гүрэн ЗХУ, БНХАУ-тай эрх тэгш, найрамдал, харилцан туслалцаж харилцах эрх зүйн өргөн боломж нээсэн нэн чухал ач холбогдолтой үйл явдал байлаа.

БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал⁴ Хятадад айлчилж, (1962.12.25-27) хоёр орны Засгийн газрын тэргүүн нар 1962 оны 12-р сарын 26-нд түүхэндээ анх удаа “Монгол, Хятадын хилийн гэрээ” байгуулав. “Хилийн гэрээ” нь хоёр орны хоорондын 4673 км урт хилийн шугамыг нарийвчлан тогтоож, Монгол, Хятадын хооронд түүхээс үлдэж хоцорсон газар нутгийн асуудлыг шийдвэрлэж чадсан нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын эвслийн Засгийн газрын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн 1992 оны 5-р сарын 7-11-нд БНХАУ-д албан ёсны айлчлал хийж Монгол, Хятадын Засгийн газар хоорондын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр, Хятадаас Монголд 30 сая юаний хүүгүй зээл олгох тухай хэлэлцээр, Засгийн газар хоорондын ургамалын хорио цээрийн тухай хэлэлцээр байгуулав. Энэ айлчлал нь 1962 оноос хойш 30 жилийн дараа Монголын Засгийн газрын тэргүүний Хятадад хийсэн айлчлал бөгөөд Монголын зах зээлийн шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад чухал ач холбогдолтой байв.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн 1994 оны 4-р сарын 28-29-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцаанд шинэ хуудас нээсэн тэмдэглэлт үйл явдал байлаа.

1960 оны 5-р сард Хятадын Ерөнхий сайд Жоу Энълай Монголд айлчилж “Монгол-Хятадын найрамдал, харилцан туслалцах гэрээ” байгуулсанаас хойш 34 жилийн дараа Хятадын Ерөнхий сайд Ли Пэн Монголд айлчилж, “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ”⁵ байгуулсан нь Монгол, Хятадын харилцааны

туулсан туршлагад үндэслэж, харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг бататгаж, 21-р зуунд хоёр орны харилцааг хөгжүүлэх тулгуур баримт бичиг болсон юм.

Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай (1996 оны 3-р сар), Р.Амаржаргал (1999 оны 11-р сар), Н.Энхбаяр (2002 оны 1-р сар), М.Энхболд (2006 оны 11-сар), С.Баяр (2009 оны 4-р сар) нар тус тус БНХАУ-д айлчилж байв.

Ийнхүү Монгол, Хятадын харилцааны өнгөрсөн жарны (1949-2009) түүхэнд хоёр орны Засгийн газрын тэргүүн нарын харилцан айлчлал олонтаа болсоны дотор Монголын талаас 9 удаа, Хятадын талаас 3 удаа айлчлал болжээ.

Монгол, Хятадын харилцааны шинэ жарны түүхийн хуудсанд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаогийн⁶ Монголд хийсэн анхны албан ёсны айлчлал зүй ёсоор тод мөрөө үлдээх болно.

Хятадын Ардын Төв Засгийн газар, гүйцэтгэх Засаглалын дээд байгууллага болох БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао 2010 оны 5-р сарын сүүлчээр Япон, БНСУ-д, 6-р сарын 1-2-нд Монголд, дараа нь Бирм улсад айлчилсан юм.

Вэнь Жябаогийн энэ удаагийн Монгол Улсад хийсэн айлчлал нь 1960 онд хоёр орны “найрамдал, харилцан туслах гэрээ” байгуулсан, БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Эньлай тэргүүтэй Хятадын Засгийн газрын дээд хэмжээний айлчлалаас хойш яг 50 жилийн дараа, 1994 онд “найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан Ерөнхий сайд Ли Гэний айлчлалаас хойш 16 жилийн дараа тохиож байгаа үйл явдал, хоёр орны харилцааны шинэ жарны эхэнд болж байгаа айлчлал, түүний Монгол Улсад анх удаагаа хийж буй айлчлал гэдгээрээ онцлог юм.

1994 онд шинэчлэн байгуулсан “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-ний үзэл санааны дагуу өнгөрсөн 16 жилд хоёр орны харилцаа хөгжиж харилцааны эрх зүйн үндэс суурь бэхжиж, бүхий л салбарыг хамарсан 80 орчим гэрээ хэлэлцээрийг хоёр тал байгуулаад байна.⁷

Ерөнхий сайд Вэнь Жябао “Энэ бол миний анхны Монгол дахь айлчлал. Монголын ард түмний халуун, дотно зочломтгой сэтгэл над гүн сайхан сэтгэгдэл үлдээлээ.”⁸ гэж Синьхуа агентлагийн сурвалжлагчид хандан мэдэгдсэн байна.

Ерөнхий сайд Вэнь Жябаогийн Монгол Улсад хийсэн айлчлал нь хоёр улсын өндөр, дээд хэмжээний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, хоёр орны ард түмний харилцан ойлгоцол, итгэлцлийг нэмэгдүүлэх, харилцааны хөгжлийн явцыг үнэлэх, цаашдын хандлагыг тодорхойлох, сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг шинэ түвшинд гаргах зорилгоо амжилттай хэрэгжүүлсэн чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газрын Ерөнхий сайд Сүхбаатарын Батболд, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао нар албан ёсны хэлэлцээ, уулзалт хийж хамтын ажиллагааны 9 баримт бичигт гарын үсэг зурлаа. Тухайлбал, “Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай” Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээнд гарын үсэг зурав. Энэ нь 1988 оны 11-р сард “Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай” Засгийн газар хоорондын гэрээг шинэчлэн байгуулсан явдал бөгөөд БНХАУ хуурай газраар хил залгадаг 14 орноос анх удаа манай улстай байгуулсан ийм төрлийн гэрээ юм. Энэ гэрээг шинэчлэн байгуулсанаар хоёр орны хилийн тогтвортой, хилийн районы амар амгалан байдлыг хамгаалах, хоёр орны хилийн дэглэмийг сахин хүндэтгэх, харилцан ойлголцох, хамтын ажиллагааны үзэл санаагаар хилийн асуудлыг зохицуулах, хилийн худалдаа, аялал жуулчлал, хилийн боомтын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хар тамхи, хүний наймаатай хамтран тэмцэх, гарсан зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчинг 1988 оны гэрээнээс илүү боловсронгуй болгожээ.

Хоёр талын хэлэлцээний үеэр эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, тэр дундаа уул уурхай, дэд бүтэц, санхүүгийн хамтын ажиллагааг уялдуулан хөгжүүлэхэд голлон анхаарсан нь хоёр талын сонирхол, эрх ашгийг хөндсөн гол асуудал байсан төдийгүй айлчлалын гол зорилгыг илтгэн харууллаа.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, энэ салбарт улс орны эдийн засгийн хүч анхаарлыг төвлөрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хамтран ажиллах боломж нөхцлийг судалж, хэрэгжүүлж буй энэ үед БНХАУ-ын Ерөнхий сайдын айлчлал тохиосон нь хоёр орны эдийн засгийг хөгжүүлэх, хөрш орны хувьд хамтдаа хөгжих таатай бололцоог бий болгож байгаагаараа нэлээдгүй ач холбогдолтой юм.

Хоёр орны Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдааны хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Засгийн газраас манай улсын Засгийн газарт 50 сая юаний буцалтгүй тусламж, (тухайн өдрийн ханшаар 7,2 сая америк доллар, 10 тэрбум гаруй төгрөг), батлан хамгаалах салбарт 10 сая юаний хөнгөлттэй зээл, манай улсын боловсруулах үйлдвэрт зориулан 500 сая ам.долларын итгэмжилсэн зээл өгөхөөр болов. Ерөнхий сайд С.Батболд “Хятад улсаас олон удаа өгч байгаа буцалтгүй тусламж нь манай улсын бүтээн байгуулалтанд дэмжлэг болж байгаад бид талархаж байгаагаа онцлон тэмдэглэхийг хүсэж байна” гэж хэлэлцээний үеэр мэдэгдэв.

Энэ удаагийн 50 сая юаний буцалтгүй тусламжийг шинжлэх ухаан, техникийн их сургуулийн оюутны хотхон байгуулах болон,

Улаанбаатар хотноо Хятадын ЭСЯ-ны урд талын зам, талбайг Бээжингийн гудамж болгон шинэчлэн тохижуулах Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд зарцуулах юм. БНХАУ-аас манай улсад нийт үзүүлсэн буцалтгүй тусламжийн хэмжээ 382 сая юаньд (76 тэрбум гаруй сая төгрөг) хүрсэнийг Сангийн сайд С.Баярцогт мэдэгджээ.¹⁰

БНХАУ-ын дарга Ху Жиньтао 2003 оны 6-р сард Монгол Улсад айлчлахдаа 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл Монголд олгохоор болсон ба хоёр талын хэлэлцээрийн үед одоо болтол ашиглаагүй байгаа уг зээлийн зарцуулалтын асуудлыг хэлэлцэж, энэ зээлийн хөрөнгөөр “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний парк нэмэгдүүлэх төсөл”-ийн зүтгүүрийн вагон худалдан авах, мөн Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурав. Ерөнхий сайд С.Батболд энэхүү зээлийг үр ашигтай зарцуулахаа мэдэгдсэн юм.¹¹

Манай улс 1958, 1960 онд Хятадаас авсан бага хүүтэй удаан хугацааны зээлийн хөрөнгөөр олон барилга байгууламж барьж байгуулсан нь тухайн үеийн улс ардын аж ахуй, хот байгуулалтанд багагүй үүрэг гүйцэтгэсэн билээ. 50 жилийн өмнөх, ойролцоогоор 28,3 сая шилжих рублийн өрийг төлөөгүй бөгөөд төлөх хугацааг сунгасан хэлэлцээр бий. Мөн 1990-ээд оны эхээр зээлсэн 130 сая юаний өрөө төлж эхлээгүй байгаа юм.¹² Аливаа нэгэн хөнгөлөлттэй зээл гэдэг бол тодорхой хэмжээний эргэн төлөгдөх өр болохоос буцалтгүй тусламж биш, зээл, тусламжийг ялган салгалгүй, нэг ойлголт мэт үздэг тал сүүлийн жилүүдэд гарч байна.

Эдгээрээс гадна, цацраг идэвхит ашигт малтмал болон цөмийн энергийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Цөмийн Энергийн газар, БНХАУ-ын Үндэсний цөмийн корпораци хоорондын санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү баримт бичгийг олон улсын ажиглагчид анхааран онцолсон байна.¹³ Учир нь Монгол Улс 30 мянган тонн ураны нөөцтэй, нийт нөөцийн тал нь Дорнод аймагт байдаг. Дорнодын ураны орд газарт Орос, Хятад Канад, Япон, Солонгос зэрэг орны эдийн засгийн сонирхол, өрсөлдөөн хүчтэй өрнөж байна.

Хятадын Ерөнхий сайдын айлчлалын явцад Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай 1993 оны хэлэлцээрийг хэрэгжүүлэх, гаалийн салбарт мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх протоколд гарын үсэг зурав. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд хятадын нутгаар хийж байгаа манай улсын транзит тээвэрт хөнгөлөлт үзүүлэх, далайд гарах боомтын тоог нэмэгдүүлэх, хил орчмын бүсэд болон Тяньжинь боомт, бусад боломжтой боомт хүртэл ачаа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх боломж бий болгох, хөдөө хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулж хятадын болон гуравдагч

орны зах зээлд нийлүүлэх, Оросоос Хятад руу тавих хий дамжуулах хоолойг Монголын нутгаар дамжуулах зэрэг асуудлыг Хятадын талд тавьж, Ерөнхий сайд Вэнь Жябао энэ талаар холбогдох байгууллагуудтай ярилцаж, судалж үзэхээ амалжээ. Хятадын талаас Монгол Хятадын чөлөөт худалдааны бүс нээх боломжийн талаар судалгаа хийж эхлэхийг санал болгов. Ерөнхий сайд С.Батболд “Бид одоо даяаршлын эрин зуунд амьдарч байна. Тэгэхээр аливаа зүйлд хамтрах ёстой болжээ” гэж тэмдэглэсэн бол Ерөнхий сайд Вэнь Жябао: “Хоёр улсын хооронд худалдаа, эдийн засгийг хөгжүүлэх өргөн боломж байгаа ч өөрсөддөө байгаа нөөц бололцоогоо ашиглаж чадахгүй байна”¹⁴ гэж хэлсэн байна. Ерөнхий сайд Вэнь Жябаогийн айлчлалын хүрээнд Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газар, БНХАУ-ын Худалдааны Яамны гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих газартай хамтран “Монгол, Хятадын худалдаа эдийн засгийн форум”-ыг 2010 оны 6-р сарын 2-нд зохион байгууллаа. Тус форумд хоёр орны Ерөнхий сайд нар, холбогдох яам, газрын удирдлага, уул уурхай, эрчим хүч, барилга, дэд бүтэц, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг төлөөлж, Монголын талаас 150, Хятадын талаас 180 орчим төлөөлөгч оролцжээ.

Форумын үеэр Хятадын “Шиньхуа” корпорацийнхан “Таван толгойн нүүрсний ордод хамтран ашигтай ажиллах саналтай байгаа. Бид харилцан ашигтай хамтран ажиллахыг хүсч байна” гэсэн бол Хятадын Экспорт Импортын Банкны (ЕХИМ) төлөөлөгч “Бид олон талын зээл олгох боломжтой. Одоогоор Төмөртэйн орд, Улаанбаатар хөгжил, орон сууцны хороолол, Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулахад зээл олгохоор болоод байна” гэдгээ мэдэгдлээ.

Айлчлалын явцад хоёр талын хүмүүнлэгийн салбарын харилцааг идэвхжүүлэх, солилцоог нэмэгдүүлж, хоёр орны ард түмний харилцан ойлголцол, найрсаг сэтгэлийг ахиулах талаар нэлээд тодорхой үр дүнд хүрлээ. Ерөнхий сайд Вэнь Жябао хоёр орны соёлын солилцооны хүрээнд Монгол Улсад нээгдсэн Хятадын соёлын төвийн нээлтийн ёслолд оролцсоны зэрэгцээ Бээжинд Монголын соёлын төв нээхэд шаардлагатай тусламж үзүүлэхээ илэрхийлэв. Ингэснээр манай улс, Хятадын Засгийн газраас хилийн чанадад Хятадын соёлын төвийг албан ёсоор байгуулсан 9 дэх орон болж байна.

2010 он гарсаар Монгол, Хятадын соёлын солилцоо, арга хэмжээ идэвхжилээ. Энэ оны эхээр Монгол Улс Хятадад “Монголын соёлын жил”-ийн ажиллагааг эхэлж, үзэсгэлэн, урлаг соёлын тоглолт зэрэг хэд хэдэн арга хэмжээ зохиов. Хоёр орны засгийн газар Улаанбаатар, Бээжин хотод харилцан соёлын төв нээх тухай болон 2010-2013 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөөнд 2010 оны 5-р сарын 1-нд гарын үсэг зурсан юм. Манай орон Шанхайн дэлхийн үзэсгэлэнд соёл урлагийн хамтлаг

оролцуулж, соёлын үзэсгэлэн нээн ажиллуулж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Хятадын хоёр тал, олон суваг, олон давхарга, олон хэлбэрийн соёлын солилцоо, хамтын ажиллагааг өрнүүлж байна.

Хоёр орны харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэхэд энгийн ардын хүн солилцоо нэн чухал. 2009 онд БНХАУ-д зорчсон монголчуудын тоо давхардсан үзүүлэлтээр 700 мянга байсан бол Монголд зорчсон хятад иргэд 200 мянгад хүрчээ.

Хятадын тал ойрын 5 жилд, жил бүр манай улсын 60 залууг Хятадад хүлээн авч айлчлуулж, Хятадын Засгийн Газрын тэтгэлгээр суралцах Монгол оюутны тоог нэмэгдүүлж, 5 жилийн дотор манай улсын 2000 оюутанг Хятадад суралцуулах болсныг Ерөнхий сайд С.Батболд мэдэгдлээ.

Монголын талын урилгаар 2010 оны 4-р сард Хөх нуур мужийн Юй Шү тосгоны газар хөдлөлтийн гамшигт өртсөн 60 сурагчийг Монголд урьж олон улсын хүүхдийн “найрамдал” зусланд амраахаар болов. Өнгөрсөн жил Сычуань мужийн газар хөдлөлтөнд нэрвэгдсэн 60 хүүхдийг мөн Монголд урьж амраасан билээ. Юй Шүгийн газар хөдлөлтөнд нэрвэгдэгсэдэд Монгол Улсын Засгийн газраас 50 мянган доллар хандивласан бол манай улсад болсон зудын хохирлыг арилгахад Хятадын Засгийн газраас 10 сая юаний эд материалын тусламж үзүүлсэн билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Монгол Улсын Их Хурлын дарга Д.Дэмбэрэл нарт Ерөнхий сайд Вэнь Жябао бараалхаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Ц.Элбэгдорж: Вэнь Жябаогийн энэ удаагийн Монголд хийсэн айлчлал баялаг үр дүнд хүрсэн нь Монгол, Хятадын харилцаа шинэ шатанд гарахад ихээхэн түлхэц болно гэлээ.

Хоёр тал Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Боловсролын үнэмлэх, эрдмийн зэргийн гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрийг сэргээв.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 7-р сарын 7-ны өдрийн хуралдаанаар БНХАУ-ын Ерөнхий сайд Вэнь Жябаогийн Монголд хийсэн албан ёсны айлчлалын үр дүнг хэлэлцээд “энэ удаагийн айлчлал хоёр орны харилцааг шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэлээ” гэж дүгнээд ялангуяа эдийн засаг, хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбаруудад нэг дор ахиц авчирсан, хүмүүнлэгийн харилцааг улам гүнзгийрүүлсэн, бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ шатны суурийг тавьсан, шинжлэх ухааны байгууллагуудын харилцаа, хөдөө аж ахуйд чухал түлхэц өгсөн айлчлал боллоо гэж үзжээ. Ийнхүү БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаогийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал өгөөжтэй, үр дүнтэй болж Монгол, Хятадын шинэ жарны харилцаа шинэ шатанд гарлаа.

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. 中新网 Zhongxinwang. 2010.06.07
2. 中国新闻网 Zhongguo xinwenwang. 2010.06.07
3. БНХАУ-ын Төрийн захиргааны Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Жоу Эньлай Женевт болсон Солонгос, Энэтхэг-Хятадын хойгийн асуудлаархи бага хуралд оролцоод буцах замдаа Хятадын Засгийн газрын тэргүүний хувьд, 1954 оны 7-р сарын 31-нээс 8-р сарын 1-нд БНМАУ-д анх удаа, албан ёсоор айлчилсан нь хоёр орны харилцааны түвшинг өндөрт гарган, дараа дараагийн жилүүдэд харилцаа өргөжин хөгжих үндэс суурийг тавьснаараа чухал ач холбогдолтой байлаа.
4. МАХН-ын Төв Хорооны 1-р нарийн бичгийн дарга, СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй Монголын төлөөлөгчид 1959 оны 9-р сарын 27-ноос 10-р сарын 5-нд БНХАУ-д айлчилж, шинэ Хятад улс байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээнд оролцжээ.
5. 1960 оны “Монгол, Хятадын найрамдал, харилцан туслалцах гэрээ”-г (“友好互助条约”), 1994 онд шинэчлэн “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээ” (友好合作关系条约) байгуулсан. Эхний гэрээнд (“найрамдал” 友好), хоёр дахь гэрээнд (“найрсаг харилцаа” 友好) гэж тодорхойлсон нь нэр томъёоны хувьд, орчуулгын үүднээс зөрүүтэй байна. Зүй нь гэрээний Хятад, Монгол эх орчуулгын хувьд нэг мөр байхсан.
6. Вэнь Жябао (温家宝 wen jia bao) гэдэг нэрийг манай албан ёсны хэвлэлд Вэнь Зябао гэж бичиж байна. Уг нь Вэнь Жябао гэж бичүүштэй. Гэтэл манай хэвлэлүүд Зя гэж бичээд хэвшчихсэн гэх бөгөөд энэ нь орос галигийн цзя-гэдгийг зя болгон авсан хэрэг бөгөөд зя-жя хоёрын хооронд ялгаатай. Ху Жинтао гэж бичдэг. Зүй нь Ху Жиньтао юм. Жин-жинь хоёрын хооронд ялгаа бий.
7. Монгол, Орос, Хятад: 21-р зуунд хөгжлийн төлөө хамтдаа. УБ. 2009. 53-р тал
8. CNR. 中国广播网 zhongguo guangbowang 2010.06.02
9. Мөн тэнд.
10. “БНХАУ 50 сая юаны буцалтгүй тусламж, 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгов. “Ардчилал” сонин. 2010.06.03. №110(949)
11. С.Батболд: Аливаа зүйлд хамтрах ёстой болжээ. “Монголын мэдээ” 2010.06.04 №109 (2938)
12. Н.Энхтайван: Шинэ Хятадын талаар маш сайн судлах хэрэгтэй, “Монголын мэдээ” сонин. 2001.07.15 №137 (2966)
13. Вэнь Жябаогийн Монгол, Бирмд хийсэн айлчлалыг дэлхий онцлов. “Өнөөдөр” сонин. 2010.06.05, №131
14. “Монголын мэдээ” 2010.06.04, №109